

**БУЛГАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2025 ОНЫ 5 САР**

2025-06-06

Булган

2025 оны 5 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **37,5** тэрбум төгрөг буюу 88,5 хувийн, нийт зарлага **31,8** тэрбум төгрөг буюу 56,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **37,5** тэрбум төгрөг буюу **88.5** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 0,9 тэрбум төгрөг буюу 2,4 хувь, урсгал орлого 1,4 тэрбум төгрөгөөр буюу 4,2 хувиар тус тус буурсан байна. Урсгал орлогын гүйцэтгэл **27,6** тэрбум төгрөг буюу **95,1** хувь байна.

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл (өссөн дүнгээр)	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт (ӨО-ны мөн үетэй харьцуулсан)	
		жилээр	тайлант үе (өссөн дүнгээр)		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	38,460.9	101,810.0	42,407.0	37,520.2	4,886.9	88.5	(940.7)	97.6
Урсгал орлого	28,948.0	68,656.7	29,457.9	27,555.6	1,902.3	93.5	(1,392.4)	95.2
Татварын орлого	26,738.1	61,271.1	26,180.4	25,323.8	856.5	96.7	(1,414.3)	94.7
Татварын бус орлого	2,209.8	7,340.5	3,268.5	2,121.0	1,147.5	64.9	(88.9)	96.0
Хөрөнгийн орлого	34.4	45.0	9.0	110.8	(101.8)	1,230.8	76.4	322.2
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	9,478.6	33,153.4	12,949.1	9,964.6	2,984.6	77.0	486.0	105.1
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	4,865.9	15,258.1	5,492.8	2,508.2	2,984.6	45.7	(2,357.7)	51.5
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,612.7	17,895.3	7,456.4	7,456.4	-	100.0	2,843.7	161.6

Нийт орлогын 26,6 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 67,5 хувийг татварын орлого, 5,9 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 10,5 тэрбум төгрөг буюу татварын орлогын 41,3 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **13,6** тэрбум төгрөг буюу **119,0** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)						
д/д	Сумын нэр	2025 он төлөв.	2025 он 5 сар төлөв.	2025 он 5 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	758.2	258.9	301.5	-42.6	116.5
2	Баяннуур	611.7	269.3	209	60.3	77.6
3	Бугат	750.4	192.2	264.5	-72.3	137.6
4	Булган	10134.1	3806.6	4796.7	-990.1	126.0
5	Бүрэгхангай	2049.6	751.7	773.4	-21.7	102.9
6	Гурванбулаг	802.7	218.8	323.5	-104.7	147.9
7	Дашинчилэн	781.4	345.1	271.2	73.9	78.6
8	Могод	712.6	236.8	268.2	-31.4	113.3
9	Орхон	1009.8	323.6	423	-99.4	130.7

10	Рашаант	1644.8	733.6	695.8	37.8	94.8
11	Сайхан	739.2	246.1	414.2	-168.1	168.3
12	Сэлэнгэ	857.2	311.9	402.7	-90.8	129.1
13	Тэшиг	1316.1	441.2	613.8	-172.6	139.1
14	Хангал	4303.6	1745.6	2315.1	-569.5	132.6
15	Хишиг-Ёндөр	811.1	378.6	319.9	58.7	84.5
16	Хутаг-Ёндөр	1744.2	763.5	751	12.5	98.4
17	Хялганат	953.3	374.6	414.9	-40.3	110.8
	СУМЫН ДҮН	29,980.0	11,398.1	13,558.4	-2160	119.0
18	Аймгийн орлого	35,031.5	16,112.6	13,064.6	3048	81.1
	НИЙТ ОРЛОГО	65,011.5	27,510.7	26,623.0	887.7	96.8

Аймгийн дүнгээр авч үзвэл цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ТТАМНАТөлбөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлого биелсэн байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 3,649.0 сая төг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг 2,984.6 сая төгрөгөөр тасарсан нь нийт орлогоын гүйцэтгэлд нөлөөлж байна. Эрдэнэт үйлдвэр ТӨХК саарал ус ашигласантай холбоотой усны төлбөр тасарсан байна. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган аймагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гадаад зээлийн эргэн төлөлтийг орон нутгийн өмчит Булган мээж ХХК, Тэшиг ус ХХК-иуд эргэн төлөх чадваргүй байгаагаас зээлийн хүүгийн орлого тасарч байна. 14 сумын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2,508.2 сая төгрөгийн шилжүүлэг ирснээс сумдын Орон нутгийн хөгжлийн санд 1,684.9 сая төгрөгийг олголоо.

2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **31,8** тэрбум төгрөг буюу **56,2** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **25,7** тэрбум төгрөг буюу **52,1** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **6,1** тэрбум төгрөг буюу **83,3** хувь байна. Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 9,824,4 сая төгрөг буюу нийт зардлын 30.9%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,007.4 сая төгрөг буюу нийт зардлын 28.3%-ийг эзэлж байна. Энэхүү 2 бүлгийн зардал нийт зардлын 59.3%-ийг эзэлж байна.

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 588,9 сая төгрөг буюу 27,7%, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 241,9 сая төгрөг буюу 5,0%, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 288,6 сая төгрөг буюу 10,0%, Замын сангийн гүйцэтгэл 166,4 сая төгрөг буюу 21,8% байна.

3. Төсвийн өглөг, авлага

Тайлант хугацаанд төсвийн байгууллагууд өр, авлага мэдээлээгүй байна.